

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн “14.2.2. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” гэсэн заалтын дагуу урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагч (цаашид “даатгагч” гэх)-тай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч нь даатгалын гэрээгээр даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний төлбөрийн чадвартай байх шаардлагыг хэрэгжүүлнэ.

1.3. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг түүний санхүүгийн тайлан тэнцэл дахь үзүүлэлтүүдийг үндэслэн тогтооно.

Хоёр. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2.1. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь **150** хувиас багагүй байна.

2.2. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг “бодит төлбөрийн чадварын үзүүлэлт”-ийг “байвал зохих төлбөрийн чадварын үзүүлэлт”-д харьцуулсан харьцаагаар тодорхойлно:

$$ТЧШҮ = \frac{А}{Б}$$

Үүнд:

ТЧШҮ- Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт;

А – Бодит төлбөрийн чадварын үзүүлэлт;

Б – Байвал зохих төлбөрийн чадварын үзүүлэлт.

2.3. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь энэ журмын 2.1-д заасан хэмжээнээс бага байвал тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй гэж үзнэ.

2.4. Энэ журмын хавсралтаар батлагдсан тайлангийн маягтын дагуу даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцно.

Гурав. Бодит төлбөрийн чадварын үзүүлэлт

3.1. Бодит төлбөрийн чадварын үзүүлэлтийг дүрмийн сангийн болон нөөцийн сангийн хөрөнгө оруулалтын нийлбэр дүнгээр тооцно:

$$А = ДСХО + НСХО$$

Үүнд:

А - Бодит төлбөрийн чадварын үзүүлэлт;

ДСХО - дүрмийн сангийн хөрөнгө оруулалтын дүн;

НСХО – нөөцийн сангийн хөрөнгө оруулалтын дүн.

3.2. Нөөцийн сангийн хөрөнгө оруулалтын дүн гэдэг нь даатгалын хэлбэр тус бүрийн хөрөнгө оруулалтын нийлбэр дүн байна.

Дөрөв. Байвал зохих төлбөрийн чадварын үзүүлэлт

4.1. Байвал зохих төлбөрийн чадварын үзүүлэлтийг дүрмийн сангийн 50 хувь болон актуарын нөөцийн сангийн 5 хувиар тооцсон дүнгийн нийлбэрээр тооцно:

$$Б = ДС \times 50\% + АНС \times 5\%$$

Үүнд:

ДС - Дүрмийн сан;

АНС- Актуарын нөөцийн сан.

4.2. Актуарын нөөцийн сан гэж даатгалын нийт гэрээний хариуцлагыг математик, магадлалын онолын аргаар тооцож байгуулсан нөөцийн санг хэлнэ.

Тав. Хяналт тавих

5.1. Даатгагч нь сар болгон, шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцож байх бөгөөд хэрэв төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

5.2. Даатгагч нь төлбөрийн чадварын тайланг энэ журмын хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр Хороонд ирүүлнэ.

5.3. Даатгагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Хорооны Даатгалын газар Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтмоожийн дагуу албадлагын арга хэмжээ авах саналыг Хороонд оруулна.

--ooOoo--

“Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын хавсралт

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЙЛАН

ДААТГАЛЫН КОМПАНИЙН НЭР: _____

ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА: _____

НЭГ. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА

(мянган төгрөг)

№	ЗҮЙЛ	ДҮН
1	ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА: (1) = (5)/(11) (зохистой харьцаа 150%-аас их)	

ХОЁР. БОДИТ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

(мянган төгрөг)

№	ЗҮЙЛ	ДҮН
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:	
3	ДҮРМИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	
4	НӨӨЦИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	
5	БОДИТ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: (5) = (3) + (4)	

ГУРАВ. БАЙВАЛ ЗОХИХ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

(мянган төгрөг)

№	ЗҮЙЛ	ДҮН
7	ДҮРМИЙН САН:	
8	ДҮРМИЙН САНГИЙН 50%: (8) = (7) x 50%	
9	АКТУАР НӨӨЦИЙН САН:	
10	НӨӨЦИЙН САНГИЙН 50%: (10) = (9) x 5%	
11	БАЙВАЛ ЗОХИХ ХАМГИЙН БАГА ХӨРӨНГӨ: (11) = (8) + (10)	

ЗАХИРАЛ: _____ ()
(гарын үсэг)

НЯГТЛАН БОДОГЧ: _____ ()
(гарын үсэг)

--ooOoo--